



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

᠔᠐ ᠕᠑ оны ᠐᠑ сарын ᠒᠐ өдөр

Дугаар ᠘/1᠙

Улаанбаатар хот

2024-2025 оны хичээлийн жилийн
төрөлжсөн олимпиадад амжилт гаргасан
сурагчдад шагнал гардуулах арга хэмжээг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.6 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хүүхэд-Хайр-Ирээдүй" уриан дор тэмдэглэн өнгөрүүлж буй Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 2024-2025 оны хичээлийн жилийн төрөлжсөн олимпиадад амжилт гаргасан сурагчдад шагнал гардуулах арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсугай.

2.Шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, амжилт гаргасан сурагчдын нэр, амжилтыг хоёрдугаар, шаардлагатай төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Арга хэмжээнд шаардагдах 3,240,000 (гурван сая хоёр зуун дөчин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 08 дүгээр сарын 20-ны өдрийн
11/11 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн

ахлагч:

Гишүүд:

Ш.Баасансүрэн

Б.Нямгарав

Н.Цэцэглэн

Э.Соёмбобат

Э.Болормаа

О.Буянхишиг

Нарийн бичгийн

дарга:

Д.Мөнхзаяа

Боловсролын хэлтсийн дарга

Нийгмийн хөгжлийн хэлтсийн

Боловсрол, соёл, урлаг

хариуцсан мэргэжилтэн

Боловсролын хэлтсийн

Сургалтын арга зүй, багшийн

мэргэжлийн хөгжил,

гүйцэтгэлийн үнэлгээ хариуцсан

мэргэжилтэн

91 дүгээр сургуулийн захирал

94 дүгээр сургуулийн захирлын

албан үүргийг түр орлон

гүйцэтгэгч

Төрийн захиргааны удирдлагын

хэлтсийн Хэвлэл мэдээллийн

ажилтан

Боловсролын хэлтсийн Төсвийн

төлөвлөлт, статистик, хөрөнгө

оруулалт, гүйцэтгэл хариуцсан

ахлах мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 05 дүгээр сарын 12-ны өдрийн
8/12 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН
ТӨРӨЛЖСӨН ОЛИМПИАДЫН ШАГНАЛ ГАРДУУЛАХ ЁСЛОЛ,
ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДЛАГАТАЙ ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1.	Медаль	ш	108.0	13,000.0	1,404,000.0
2.	Аяга (Хэвлэлтэй)	ш	108.0	10,000.0	1,080,000.0
3.	Батламж	ш	108.0	2,000.0	216,000.0
4.	Сугалаа	ш	108.0	5,000.0	540,000.0
Нийт					3,240,000.0